

**ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2024 он

ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Энэхүү үнэлгээний зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад оршино.

Даатгалын зуучлагчид тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлж, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилтыг тодорхойлсон байна.

Иймд хуулийг хэрэгжүүлэх холбогдох байгууллагад нөлөөлөл үзүүлэх зардлыг тооцов.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- ✓ Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- ✓ Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- ✓ Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- ✓ Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

НЭГ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Санхүүгийн зохицуулах хороо нь Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах бөгөөд тус хуулийн төсөлтэй холбоотойгоор төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэмэгдэхгүй, ажил, үйлчилгээг гүйцэтгэх нэмэлт хүний нөөц шаардлагагүй. Мөн холбогдох нэмэлт зардал гарахааргүй байна.

Гарах зардлыг урьдчилан тооцох:

Бусад холбогдох материаллаг зардлыг аргачлалд зааснаар дараах байдлаар тооцов. Үүнд:

1.1 Материаллаг зардлыг тооцох:

Банк даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдүүдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шаардлагагүй тул холбогдох зардал гарахгүй.

1.3 Хялбарчлах боломж:

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотойгоор төрийн байгууллагын зардлыг бууруулах боломжийг аргачлалд заасны дагуу дараах шалгууруудаар тодорхойлж үзлээ. Үүнд:

Хамрагдах тоог багасгах боломж байгаа эсэх: Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд заасны дагуу хэд хэдэн даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгохоор заасан. Иймд банк бус санхүүгийн байгууллага, сүлжээ дэлгүүр, аялал жуулчлалын компани зэрэг хуулийн этгээдүүд нэмэгдэхээр байгаа тул хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй.

Мэдээллийн агуулга, давтамжийг багасгах боломж байгаа эсэх: Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд заасны дагуу хэд хэдэн даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгохтой холбоотой мэдээллийн агуулга давтамжийг бууруулах боломжгүй.

Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх: Одоо мөрдөгдөж байгаа хуулиар хуулийн этгээдэд ямар нэгэн үүрэг байгаагүй болно.

Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх: Шинэчлэн найруулсан хуулийн төслөөр мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр ирүүлэх боломжтой.

Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах:

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр хуулийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх зардал одоогийн хэмжээнээс ялгаагүй болно.

ХОЁР.НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Хуулийн төсөл батлагдсанаар даатгалын салбарын гол борлуулалтын суваг болох даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг төрөлжүүлэх, эрх үүргийг нь тодорхой болгох, даатгуулагчид мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, даатгалын үйлчилгээний ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой болно.